



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/181

Арвайхээр

**Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл  
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.1, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг тухай бүр хангаж, орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн жил бүрийн 01 дүгээр сард Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд хүргүүлэхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Т.Нарангарав)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл байгуулах тухай” А/189 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100394

Аймгийн Засаг даргын 2021 оны...*ОН*  
дугаар сарын...*20*...ны өдрийн...*2021*...дүгээр  
захирамжийн хавсралт



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АЙМГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр,  
халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр  
эрхлэлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын  
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн  
үйлчилгээний газрын дарга

Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
дарга

Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуучлал, албан бус  
секторт ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

Иргэний засаглал төрийн бус байгууллагын тэргүүн

Худалдаа аж үйлдвэрийн танхимын Өвөрхангай аймаг дахь  
салбарын дарга

-оОо-